



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 95


Улаанбаатар хот

┌ Нэмж гаргасан хувьцааг нийтэд санал болгохыг ┐  
зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.4.12, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 47 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 689 дүгээр тогтоолоор бүртгэсэн “Сүү” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэ бүхий нийт 85,589,000 /наян таван сая таван зуун наян есөн мянга/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН